



91

БНМАУ  
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ЗАХИРАМЖ

1993 оны 3 сарын 04 өдөр

Дугаар 432

Улаанбаатар хот

Худалдаа, хоолны "Жаргалант" компани /УУГ/ байгуулах тухай

1. Сүхбаатар дүүргийн Худалдаа, хоолны компаний харьяанд ажиллаж байсан 7 дугаар гуанзныг аж ахуйн нэгжийн хуулийн нэгдүгээр бүлгийн 2, 3 дугаар зүйлд заасны дагуу Худалдаа, хоолны "Жаргалант" компани /УУГ/ болгон зохион байгуулж, дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

2. "Жаргалант" компаний үндсэн хөрөнгийг дахин үнэлж, төрийн өмчийн эзнийг төлөөлж тус компанитай гэрээ байгуулж ажиллахыг нийслэлийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх Өмчийн газар /н.Найдан/-т даалгасугай.

3. Худалдаа, хоолны "Жаргалант" компани /УУГ/-ын захирлаар Готов овогтой Баярмагнайг томилж, сарын цалинг 8000 төгрөгөөр тогтоосугай.

4. "Богдхангай" хамтарсан үйлдвэрийн газрын асуудлыг судлан боловсруулж Хятадын талтай шинээр хэлэлцээр хийхийг Нийслэлийн Засаг даргын Хүнс, хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээний асуудал эрхэлсэн орлогч /н.Жанцан/, "Жаргалант" компаний захирал /н.Баярмагнай/ нарт даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ  
ЦАГА

*[Handwritten signature]*

Ц.БААСАНЖАВ



Нийслэлийн засаг даргын 1993 оны 4-32 тоот захирамжийн хавсралт:

НИЙТИЙН ХООЛ ХУДАЛЦААНЫ "ЖАРГАЛАНТ" КОМПАНИЙ ДҮРЭМ.

НЭГ. Ерөнхий зүйл

1.1. Жаргалант компани нь Монгол улсын аж ахуйн нэгжийн тухай хуулийн үндсэн дээр байгуулагдсан нийтийн хоол худалдаа, үйлчилгээ эрхлэх улсын үйлдвэрийн газар мөн.

1.2. Компани нь өөрийн нэрийн өмнөөс нийтийн хоол худалдаа үйлчилгээг тогтвортой эрхлэж төрөөс оруулсан хөрөнгөөс бүрдсэн дүрмийн сантай хүлээсэн үүргээ эд хөрөнгөөрөө хариуцах зарчимар ажиллана.

1.3. Компани нь Монгол улсын хууль тогтоомж, нийслэлийн засаг даргын шийдвэр болон холбогдох эрх зүйн актыг мөрдлөгө болгон амиллана.

1.4. Компани нь тогтоосон журмын цагуу тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкинд харилцах данстай байна.

1.5. Компани нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өнрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулна.

1.6. Компани нь өөрийн зүгээс хүлээсэн гэрээ хэлэлцээрийн заалт зах зээлийн нугарга зарчим, амиллагсааны эрх ангийг хамгаалах зэрэг асуудалд үйл ажиллагааг чарлуулна.

1.7. Компани нь Монгол улсын хөдөлмөрийн хуулийн цагуу амиллагсаантайгаа гэрээг бичгээр үйлдэн хоёр талаас хүлээх хариуцаагыг зохицуулна.

ХОЁР: Компаний нэр хаяг, орших газар

2.1. Компаний албан ёсны нэрийг монголоор Нийтийн хоол худалдааны "ЖАРГАЛАНТ" компани гэнэ.

2.2. Компани нь Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн нутагт байрлана.

2.3. Компани албан ёсны хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот - Баянцоржийн гудамж 17.  
Нийтийн хоол Худалдаа үйлчилгээний "Жаргалант" компани  
/Улсын үйлдвэрийн газар./

2.4. Компаний санбар нь Улаанбаатар хот болон эзэр нутгийн аль ч дүүрэг аймаг хотоц байрлаж болох бөгөөд тэдгээр нь зохих хууль тогтоомжийн дагуу бүртгүүлж ажил үйлчилгээ явуулна.

2.5. Компаний санбар ам ахуйн нэгжид гадаад дотоодын аль ч улсад байгуулж болох бөгөөд тэдгээрийн ажиллах зарчмыг тухайн улсын болон Монгол улсын зохих хууль, тогтоомжинд нийдүүлсэн байна.

ТЭГЭВ: Компаний эрхлэх ажил.

Нийтийн хоол худалдаа, үйлчилгээний "Маргаант" компани нь хөрхи ажил эрхлэнэ. Үүнд:

3.1. Нөөц боломжийг бүрэн дүүрэн ашиглан нийтийн хоол гадаад дотоод худалдаа үйлчилгээг эрхлэнэ.

3.2. Нийтийн хоол, худалдаа үйлчилгээний соёл, үр ашгийг байнга дээшлүүлж хөрөнгөтний хэрэгцээг хангах зорилгоор шинэ арга амллагааг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.

3.3. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ болон техник технологийн хөгжил, зохион байгуулалтын ба бусад шаардлагыг үндэслэн нийтийн хоол, худалдаа үйлчилгээний нэгж шинээр зохион байгуулах болон татан буулгана.

3.4. Үйлдвэр, худалдаа, үйлчилгээнд үндсэн туслах материал түүхий эц дамжлаган дулаан уур ус болон бусад ажил үйлчилгээний асуудлаар харилцагч байгууллагуудтай ам ахуйн гэрээтэй ажиллана, гэрээгээр хүлээнэ үүргээ чанд биелүүлж ажиллана.

3.5. Компани нь дотоод гадаадын байгууллагуудтай харилцаанаа өргөтгөн хөрши ажиллаж, бараа солилцох, хамтарсан үйлдвэр цех байгуулах, өөрийн ажил чиглэлээр бусад зуучлах зэргээр шууд хамтын ажиллагааны ашигтай бүхийн халбарийг сонгон өргөжүүлэх замаар үйлдвэрлэл үйлчилгээнийгэмэгцүүлж байна.

3.6. Боловсон хүчин бэлтгэх, тэдний мэдлэг мэргэжлийг

дээшлүүдэх талгаар байнга амьдарч ажиллана. Түүнчлэн нийтийн хөөл худалдаа үйлчилгээний техник технологийнтой холбогдох патент, лиценз худалдан авах, солилдох үйл ажиллагааг харилцан ашигтай хэлбэр нөхцөлөөр хэрэглүүлнэ.

4.1. Дүрмийн сангийн хэмжээ, түүнийг өөрчлөх

4.1. Компаний дүрмийн сангийн хэмжээ нь Сүхбаатар дүүргийн хуцалдаа хоолны компаниас хүлээн авсан хөрөнгийн хэмжээгээр эхний ээлжинд тооцогдоно.

4.2. Дүрмийн санг өөрчлөлт орох уг асуудлыг компаний бүх гишүүдийн журлаар шийдвэрлэнэ. Дүрмийн санг өөрчлөх шийдвэр зарснаа хойш 14 хоногийн дотор зах улсын бүртгэлд бүртгүүлсэн тэр байгууллагадаа мэдэгдэнэ.

4.3. Дүрмийн санг өөрчилсөн тухай шийдвэрийг улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хуучин төшөлцөрт тооцно.

4.2. Компаний удирдлага

5.1. Компаний удирдлага үйл ажиллагааг захирал удирдал түүнийг томилсон байгууллагааа ажлаа тайлагнана.

5.2. Компаний захирлыг нийслэлийн засаг дарга томилж гэрээ байгуулна.

5.3. Гэрээнд компаний захирлын ажиллах хугацаа, гэрээ байгуулагч талуудын эрх үүрэг, харуцлага, цалин хөлс, нийгмийн ахуйн болон бусад нөхцөл, гэрээг цуцах үндэслэл зэргийг тусгана.

5.4. Компаний захирал, захиргааны зөвлөлийн гишүүц аж ахуйн бусад нэгжийг эзлүүх, удирдлагын бүрэлдхүүнд байхыг хориглоно. Харин хувьцаа эзэмшигч байх болно.

5.5. Компаний захирал, үйлдвэрийн газрыг төлөөлж дараахь эрх эдлэнэ.

а. компаний нарийн өмнөөс бусад байгууллага иргэдтэй шууд харилцаж хөдөлмөр иргэний болон бусад гэрээ хэлэлцэл хийх.

б. байгууллагын эд хөрөнгийг Монгол улсын хууль тогтоомжинд зогсны дагуу захиран зарцуулах.

в. компаний захиргааны бэлж бусад албан тушаалтан салбар нэгжийн удирдлагын томилж, чөлөөлөх.

г. үйлдвэрлэл, технологийн нууцад хамраах мэдээлэлийг тогтоох.

5.6. Компаний захирад Монгол улсын хууль тогтоомжинд нийцүүлэн тушаал заавар гаргана. Тушаал зааварыг компаний үйл ажиллагааны хүрээнд мөрдөнө.

ЗУРГАА: Ашиг түүнийг хуваарилах.

6.1. Компаний цэвэр ашгийг тодорхойлохдоо жилийн нийт орлогоос тодорхой төсөл ажил үйлчилгээг гүйцэтгэхэд гарсан зардал, цалин шимтгэл, төсвийн төлбөр гааль хуцалцааны татвар хураамжийг хасаж тооцно.

6.2. Цэвэр ашигаас дүрмийн сангийн 20%-тай тэнцэх хэмжээгээр сан байгуулж уг санг үйлчилгээг өргөтгөх, ажиллагчдын нийгэм соёлын хэмжээнд зарцуулна.

ДОЛОО: Татан буулгах, эцсийн тооцоо хийх

7.1. Компаний үйл ажиллагааг доор дурьдсан үндэслэлээр зогсоож болно.

- Гэрээ дүрмээр зохицуулагдсан хугацаа дуусах
- Нүүхийн шийдвэрээр
- Харьяалах төрийн захиргааны эрх бүхий байгууллагын шийдвэрээр
- Хуульд заасан бусад үндэслэлээр

7.2. Эцсийн тооцоо хийж буй удирдлага нь:

- Энэ тухай банк болон сонирхогч этгээцүүдэд мэдэгцэнэ.
- Дуусгалтын тайлан тэнцлийг гаргаж, нийслэлийн засаг даргын, тамгын газар, албан газарт танилцуулна.

-Эцсийн тооцоо хийж дууссаныг бүртгэх байгууллагад мэдэгдэж бүртгэлээс хасуулна.

-Улсын бүртгэлээс хасах тухай бүртгэх байгууллагаас шийдвэр гарсны дараа компанийг татан буулгах тухай нийтэд зарлана.

- Эцсийн тооцоо хийж байгаа удирдлага, ажиллагсдын хооронд гарсан маргааныг хуулийн байгууллага шийдвэрлэнэ.